



МОНГОЛ УЛСЫН  
ДЭЭД ШҮҮХ

# 2024 ОНЫ ТАЙЛАН



## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА


|                                                           |    |
|-----------------------------------------------------------|----|
| 1. ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА..... | 3  |
| 1.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ.....                         | 4  |
| 1.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ.....                          | 8  |
| 1.3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ.....                       | 12 |
| 1.4. САХИЛГЫН ХЭРЭГ.....                                  | 19 |
| 2. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖИЛ.....              | 21 |
| 2.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ.....                         | 21 |
| 2.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ.....                          | 32 |
| 2.3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ.....                       | 39 |
| 3. ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЛБА.....                       | 48 |
| 4. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР.....            | 52 |
| 4.1. ЗАХИРГАА УДИРДЛАГА.....                              | 52 |
| 4.2. ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА.....                   | 60 |
| 4.3. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА.....               | 61 |
| 4.4. УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ.....                        | 64 |
| 4.5. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ.....                       | 66 |

## 1.ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Монгол Улсын дээд шүүх хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд хяналтын журмаар гаргасан гомдлуудыг хүлээн авч хянан шийдвэрлэх ажиллагаа явуулав.


**Монгол Улсын дээд шүүхэд хүлээн авсан нийт 3101 хэрэг**

Зураг 1



**Монгол Улсын дээд шүүхэд 2024 онд хүлээж авсан хэргийг  
2023 онтой харьцуулсан үзүүлэлт**

Зураг 2




## 1.1.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 6 хэрэг, нэмж хяналтын шатны журмаар 965, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулах дүгнэлт болон цагаатгалын 20, шүүхийн харьяалал тогтоолгохоор 18, нийт 1009 хэрэг хүлээн авснаас 837 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, 2 хэрэгт гомдол гаргагч гомдлоосоо татгалзаж, 144 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, 18 хэргийн шүүхийн харьяаллыг тогтоох эсэх асуудлыг шийдвэрлэж, одоо хуваарилагдсан нийт 8 хэргийн үлдэгдэлтэй байна.

### Нийт хүлээн авсан эрүүгийн хэрэг 1009


Зураг 3



Тайлангийн хугацаанд Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар 963 хэргийн гомдол болон холбогдох шүүхийн шийдвэрүүдийг хэлэлцсэнээс 837 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, 2 хэрэгт гомдол гаргагч гомдлоосоо татгалзаж, хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, 126 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

### Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцсэн хэрэг 963

Зураг 4



Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар шийдвэрлэсэн **963** хэргийг шүүгдэгчийн гаргасан **312**, шүүгдэгчийн өмгөөлөгчийн гаргасан **837**, хохирогчийн гаргасан **58**, хохирогчийн өмгөөлөгчийн гаргасан **63**, иргэний хариуцагчийн гаргасан **24**, иргэний нэхэмжлэгчийн гаргасан **5**, прокурорын бичсэн **134** эсэргүүцлээр буюу нийт **1433** гомдол, эсэргүүцлээр хянан хэлэлцжээ.

Хяналтын шатын эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **144** хэргийг зүйлчлэлээр авч үзвэл:


Эрүүгийн хуулийн Аравдугаар бүлгээр **24**, Арван нэгдүгээр бүлгээр **17**, Арван хоёрдугаар бүлгээр **17**, Арван гуравдугаар бүлгээр **2**, Арван тавдугаар бүлгээр **1**, Арван долоодугаар бүлгээр **15**, Арван наймдугаар бүлгээр **5**, Хорьдугаар бүлгээр **2**, Хорин нэгдүгээр бүлгээр **6**, Хорин хоёрдугаар бүлгээр **22**, Хорин гуравдугаар бүлгээр **3**, Хорин дөрөвдүгээр бүлгээр **1**, Хорин долоодугаар бүлгээр **10**, шинээр илэрсэн нөхцөл байдал болон цагаатгалын **17**, шинээр илэрсэн нөхцөл байдал **2**, нийт **144** гомдол, эсэргүүцлийг хяналтын журмаар хянан хэлэлцжээ.

Эрүүгийн хэргийн хяналтын шатны хуралдаан **37** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **3.9** хэрэг, танхимын нийт шүүгчийн хуралдаан **43** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **22.4** хэрэг хэлэлцжээ.

Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **807**, шүүгч Б.Амарбаясгалан **683**, С.Батдэлгэр **793**, Б.Батцэрэн **847**, С.Соёмбо-Эрдэнэ **936**, М.Пүрэвсүрэн **830**, Б.Цогт **795** хэргийн гомдлыг тус тус хянан хэлэлцсэн байна.

#### Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар шүүгчдийн оролцсон тоо

Зураг 5



Хяналтын журмаар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **144** хэргийн **14.58** хувь буюу **21** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, **36.81** хувь буюу **53** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, **47.22** хувь буюу **68** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан **53** хэргийн **71.70** хувь буюу **38** хэргийг Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн, **13.21** хувь буюу **7** хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр тус тус өөрчлөлт оруулж, **15.09** хувь буюу **8** хэргийн зүйлчлэлийг өөрчлөлгүйгээр ялыг хөнгөрүүлжээ.

Хүчингүй болгосон **68** хэргийн **10.29** хувь буюу **7** хэргийн шийтгэх, цагаатгах тогтоол, магадлалыг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, **48.53** хувь буюу **33** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, **20.59** хувь цагаатгалын хэрэг **14**, **20.59** хувь буюу **14** хэргийг бусад үндэслэлээр хүчингүй болгожээ.

Тайлант хугацаанд Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **15**, шүүгч Б.Амарбаясгалан **21**, С.Батдэлгэр **20**, Б.Батцэрэн **22**, Б.Цогт **24**, С.Соёмбо-Эрдэнэ **26**, М.Пүрэвсүрэн **24** хэргийг тус тус хүлээн авчээ.

#### Шүүгч тус бүрийн хяналтын журмаар шинээр хүлээн авсан хэрэг

Зураг 6




Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **57**, шүүгч Б.Амарбаясгалан **63**, С.Батдэлгэр **132**, Б.Батцэрэн **132**, С.Соёмбо-Эрдэнэ **142**, М.Пүрэвсүрэн **141**, Б.Цогт **117** удаа тус тус оролцсоноос:

Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **17**, шүүгч Б.Амарбаясгалан **19**, С.Батдэлгэр **16**, Б.Батцэрэн **17**, М.Пүрэвсүрэн **24**, С.Соёмбо-Эрдэнэ **27**, Б.Цогт **24** удаа шүүх хуралдааныг даргалж;

Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **15**, шүүгч Б.Амарбаясгалан **19**, С.Батдэлгэр **20**, Б.Батцэрэн **21**, Б.Цогт **22**, С.Соёмбо-Эрдэнэ **24**, М.Пүрэвсүрэн **23** эрүүгийн хэрэг илтгэсэн байна.

**Хяналтын шатны шүүх хуралдаанд шүүгчдийн оролцоо, албан бичиг, өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байдал**

Зураг 7



Эрүүгийн танхим 2024 онд нийт **108** албан бичиг хүлээж авснаас шүүгч Б.Амарбаясгалан **3**, Б.Батцэрэн **12**, С.Батдэлгэр **1**, Ч.Хосбаяр **81**, С.Соёмбо-Эрдэнэ **7**, М.Пүрэвсүрэн **2**, Б.Цогт **2** албан бичиг шийдвэрлэсэн.

Мөн тайлант хугацаанд нийт **27** өргөдөл, гомдол хүлээн авснаас шүүгч Б.Амарбаясгалан **3**, С.Батдэлгэр **4**, Ч.Хосбаяр **16**, Б.Цогт **1**, М.Пүрэвсүрэн **2**, С.Соёмбо-Эрдэнэ **1** өргөдөл, гомдол тус тус хүлээн авч, шийдвэрлэжээ.

Мөн Захиргаа, Иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны бүрэлдэхүүнд Танхимын тэргүүн Ч.Хосбаяр 35, шүүгч Б.Амарбаясгалан 3, Б.Батцэрэн 1, М.Пүрэвсүрэн 5, С.Батдэлгэр 3, С.Соёмбо-Эрдэнэ 4, Б.Цогт 21 гомдлын хуралдаанд тус тус оролцож, шүүгч С.Соёмбо-Эрдэнэ Иргэний танхимын хяналтын шатны шүүх хуралдааны бүрэлдэхүүнд 1, Захиргааны танхимын хяналтын шатны шүүх хуралдааны бүрэлдэхүүнд 1 удаа оролцжээ.

Улсын ерөнхий прокурорын газраас прокурорын дүгнэлт бичиж ирүүлсэн 16 цагаатгалын хэргийг хүлээн авснаас 17 хэлмэгдэгчид холбогдох 12 хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж, 4 хэргийн прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож шийдсэн байна.

Цагаатгалын бүртгэлд 17 хэлмэгдэгчийн мэдээллийг шинээр оруулж, 2 хэлмэгдэгчдийн мэдээллийг нөхөн хөтөлсөн.

Шинээр олгосон 2, нөхөн 1 цагаатгалын үнэмлэхийг цахим санд бүртгэж, 21 аймаг, 9 дүүргээс ирүүлсэн нөхөх олговор олгосон нийт 34 шүүхийн шийдвэрүүдийн мэдээллийг оруулсан.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж 214 гарснаас шүүхийн харьяалал тогтоох тухай 6, шүүгч томилон ажиллуулах тухай 208 захирамж гарчээ. Мөн танхимын зөвлөгөөний тогтоол 102, шүүхийн тогтоол 44, мэдэгдэх хуудас 92 гарсан байна.

## **1.2.ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ**


Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл нийт 8 /хяналтын журмаар хүлээн авсан 6, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт 1, шүүхийн харьяалал тогтоолгох 1/ хэрэг, нэмж хяналтын шатны журмаар 1549, харьяалал тогтоолгохоор 20, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар 19, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг хүчингүй болгуулахаар 1, нийт 1597 хэрэг хүлээн авснаас 1579 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс танхимын нийт шүүгчийн хуралдаанаар 1171 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, 41 хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхгүй буцааж, 321 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 4 хэргийг гомдол гаргаагүйд тооцож, 1 хэрэг хяналтын шүүх хуралдааны үед гомдлоосоо татгалзаж, 20 хэргийн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг хэлэлцэж, 21 хэрэгт шүүхийн харьяаллыг тогтоож, одоо хуваарилагдсан хяналтын журмаар хүлээн авсан 18 хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд Иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаан 44 өдөр хуралдаж, нийт 1549 хэрэг хэлэлцсэнээс 333 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр, 1171 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, 5 хэрэг хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, 41 хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхгүй буцааж шийдвэрлэсэн байна.



## Нийт хүлээн авсан иргэний хэрэг 1597

Зураг 8




**Иргэний хэргийн танхимын** хяналтын шатны болон танхимын нийт шүүгчийн хуралдаан нийт **89** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **17** хэрэг хэлэлцжээ.

Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **1504**, шүүгч Н.Батзориг **1481**, Н.Батчимэг **1549**, Н.Баярмаа **1517**, П.Золзаяа **1548**, Д.Цолмон **1472**, Х.Эрдэнэсүвд **1165** хэргийн гомдлыг тус тус хянан хэлэлцсэн байна.

## Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцсэн хэрэг

Зураг 9



Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн иргэний **321** хэргийн **20.5** хувь буюу **66** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **16.5** хувь буюу **53** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, **35.9** хувь буюу **112** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, **23.7** хувь буюу **74** хэргийн магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, **5.1**

хувь буюу **16** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан **112** хэргийн **89.6** хувь буюу **80** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **1.12** хувь буюу **12** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ. Шийдвэр магадлалд өөрчлөлт оруулсан **20** тогтоол албажаагүй байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **53** хэргийн **45.3** хувь буюу **24** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, **5.6** хувь буюу **3** хэргийг зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, **30.2** хувь буюу **16** хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн **18.9** хувь буюу **10** хэргийг нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.


Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **16** хэргийн **6.25** хувь буюу **1** нь зохигчийн эвлэрлийг баталсан, **12.5** хувь буюу **2** нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, **81.25** хувь буюу **13** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлттэй **20** хэргийг тайлангийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд **19** хэргийн хүсэлтийг хангаагүй, **1** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хүчингүй болгож, хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн байна.

**Хяналтын журмаар** танхимын тэргүүн Г.Алтанчимэг **33**, шүүгч Н.Батзориг **48**, Н.Батчимэг **49**, Н.Баярмаа **48**, П.Золзаяа **50**, Д.Цолмон **50**, Х.Эрдэнэсүвд **43** хэрэг тус тус шинээр хүлээн авчээ.

### Шүүгч тус бүрийн хяналтын журмаар шинээр хүлээн авсан хэрэг

Зураг 10




**Хяналтын шатны** Иргэний хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **135**, шүүгч Н.Батзориг **147**, Н.Батчимэг **152**, Н.Баярмаа **151**, П.Золзаяа **153**, Д.Цолмон **159**, Х.Эрдэнэсүвд **90**, бусад танхимаас **1** удаа бүрэлдэхүүнд **оролцож**;

Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **43**, шүүгч Н.Батзориг **52**, Н.Батчимэг **60**, Н.Баярмаа **55**, П.Золзаяа **48**, Д.Цолмон **39**, Х.Эрдэнэсүвд **29** хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **33**, шүүгч Н.Батзориг **48**, Н.Батчимэг **50**, Н.Баярмаа **50**, П.Золзаяа **51**, Д.Цолмон **50**, Х.Эрдэнэсүвд **44** хэргийг тус тус **илтгэсэн** байна.

### Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2024 оны бүтэн жилийн байдлаар хяналтын хуралдаан оролцсон байдал

Зураг 11



Тус танхим 2024 оны жилийн эцсээр иргэн, хуулийн этгээдээс нийт **61** албан бичиг хүлээн авснаас Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **14** албан бичиг, шүүгч Н.Батзориг **8** албан бичиг, шүүгч Н.Батчимэг **8** албан бичиг, шүүгч Н.Баярмаа **9**

албан бичиг, шүүгч П.Золзаяа **9** албан бичиг, шүүгч Д.Цолмон **8** албан бичиг, шүүгч Х.Эрдэнэсүвд **5** албан бичиг, **25** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **3** өргөдөл, гомдол, шүүгч Н.Батзориг **3** өргөдөл гомдол, шүүгч Н.Батчимэг **3** өргөдөл гомдол, шүүгч Н.Баярмаа **4** өргөдөл, гомдол, шүүгч П.Золзаяа **4** өргөдөл, гомдол, шүүгч Д.Цолмон **4** өргөдөл, гомдол, шүүгч Х.Эрдэнэсүвд **4** өргөдөл, гомдол тус тус хүлээн авч хянан шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **48.3** хувь буюу **118** нэхэмжлэгчийн, **46.7** хувь буюу **114** хариуцагчийн, **5** хувь буюу **12** зохигчийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **321** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл, Иргэний хуулиар **234**, Хөдөлмөрийн тухай хуулиар **54**, Гэр бүлийн тухай хуулиар **13**, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **8**, бусад хуулиар **12** хэргийг хянан шийдвэрлэжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилсон шийдвэрийг албажуулах тухай” **447** захирамж, **70** шүүхийн тогтоол гарснаас шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт шийдвэрлэсэн **20**, шүүх хуралдаан хойшлуулсан **31**, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчингүй болгох тухай **1**, хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзсаныг баталсан **1**, хүсэлт хэрэгсэхгүй болгосон **17** тогтоол гарсан байна.

Танхимын нийт шүүгчийн хуралдааны тогтоол **1629** гарснаас, хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай **333**, шүүхийн харьяалал тогтоох тухай **21**, тогтоол албажуулах хугацаа сунгах тухай **48**, хуралдаан хойшлуулах тухай **4**, хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тухай **1175**, гомдлоосоо татгалзсан **4**, гомдлыг хэлэлцэхгүй буцаах тухай **41**, шүүх хуралдаанаас татгалзан гарах хүсэлт шийдвэрлэсэн **3** тогтоол тус тус гарсан байна.

### **1.3.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ**


Захиргааны хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **15** хэрэг, нэмж (2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл) хяналтын журмаар **479**, давж заалдах журмаар **25**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлт **5**, нийт **524** хэрэг хүлээн авч, **111** хэргийг хяналтын журмаар, **27** хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэж, **7** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг хэлэлцэж, **1** хэргийг нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож, **1** хэргийг нэхэмжлэгч, хариуцагчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож, **1** хэргийн хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож, **359** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **3** хэргийн оролцогч хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, гомдол гаргаагүйд тооцож, **7** хэргийн хяналтын журмаар гомдол гаргах хугацаа хэтэрснийг буцааж одоо хуваарилагдсан нийт **7** (хяналтын журмаар хүлээн авсан **5**, давж заалдах журмаар **2**) хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаан **40** өдөр хуралдаж, нийт **479** хэрэгт гаргасан гомдлыг хяналтын

шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг хэлэлцсэнээс **111** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр, **359** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **7** хэргийн хяналтын журмаар гомдол гаргах хугацаа хэтэрснийг буцааж, **2** хэргийн оролцогч хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, гомдол гаргаагүйд тооцож шийдвэрлэсэн байна.

### Нийт хүлээн авсан захиргааны хэрэг 524

Зураг 12




Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны болон танхимын нийт шүүгчийн хуралдаан нийт **74** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **8.3** хэрэг хэлэлцжээ.

Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **479**, шүүгч П.Соёл-Эрдэнэ **476**, Г.Банзрагч **476**, Д.Батбаатар **471**, М.Батсуурь **460**, Х.Батсүрэн **457**, Ц.Цогт **382** хэргийн гомдлыг тус тус хянан хэлэлцсэн байна.

### Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцсэн хэрэг

Зураг 13



Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны **138** хэргийн **30** хувь буюу **41** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **21** хувь буюу **29** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулж, **17.3** хувь буюу **24** хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийдвэрт өөрчлөлт оруулж, **7.2** хувь буюу **10** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангасан, **1.4** хувь буюу **2** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон, **3** хувь буюу **4** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон, **13.6** хувь буюу **19** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан, **6.5** хувь буюу **9** хэргийн магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр давж заалдах шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн байна.

Шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулсан **29** хэргийн **58.6** хувь буюу **17** нь шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, **20.6** хувь нь буюу **6** нь хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, **6.8** хувь буюу **2** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн, **14** хувь нь буюу **4** нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой үндэслэлээр;

Магадлалыг хүчингүй болгож, шийдвэрт өөрчлөлт оруулсан **10** хэргийн **80** хувь буюу **8** нь шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, **20** хувь буюу **2** нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэсэн үндэслэлээр;

Магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн **14** хэргийн **71.5** хувь буюу **10** хэргийг шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, **14.3** хувь буюу **2** хэргийг хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, **7.1** хувь буюу **1** хэргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, **7.1** хувь буюу **1** хэргийг эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэх үндэслэлээр тус тус шийдвэрлэжээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **28** хэргийн **82.1** хувь буюу **23** хэргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, **3.6** хувь буюу **1** хэргийг хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, **14.3** хувь буюу **4** хэргийг шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **2** хэрэгт хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан **10** хэргийн **70** хувь буюу **7** хэргийг шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, **20** хувь буюу **2** хэргийг хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, **10** хувь буюу **1** хэргийг эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэсэн үндэслэлээр шийдвэрлэсэн.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон **4** хэргийн **25** хувь буюу **1** хэргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт


нөлөөлсөн, **75** хувь буюу **3** нь хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлттэй **7** хэргийг тайлангийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд хүсэлтийг хангаагүй **7** байна.

Шүүгч тус бүрийн нийт хүлээн авсан хэрэг шүүгч Х.Батсүрэн **24**, Г.Банзрагч **23**, Д.Батбаатар **22**, П.Соёл-Эрдэнэ **22**, шүүгч М.Батсуурь **21**, Ц.Цогт **21**, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **12** хэрэг тус тус хүлээн авчээ.

#### Шүүгч тус бүрийн нийт хүлээн авсан хэрэг:

Зураг 14



**Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд** Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **113**, шүүгч Х.Батсүрэн **101**, Г.Банзрагч **100**, М.Батсуурь **97**, П.Соёл-Эрдэнэ **96**, Д.Батбаатар **93**, Ц.Цогт **89** удаа оролцсоноос;


Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **24**, шүүгч Г.Банзрагч **24**, П.Соёл-Эрдэнэ **22**, Х.Батсүрэн **21**, шүүгч М.Батсуурь **18**, Д.Батбаатар **15**, Ц.Цогт **14** хэргийн шүүх хуралдааныг даргалж;

Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **77**, шүүгч М.Батсуурь **59**, Х.Батсүрэн **58**, шүүгч Д.Батбаатар **57**, Ц.Цогт **55**, Г.Банзрагч **54**, П.Соёл-Эрдэнэ **54** хэргийн шүүх бүрэлдэхүүнд;

Шүүгч тус бүрийн нийт хүлээн авсан хэрэг шүүгч Г.Банзрагч **22**, Х.Батсүрэн **22**, П.Соёл-Эрдэнэ **21**, Д.Батбаатар **21**, М.Батсуурь **20**, Ц.Цогт **20**, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **12** хэрэг илтгэсэн байна.

## Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн 2024 оны сүүлийн хагас жилийн ажлын ачаалал

Зураг 15



Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт хэлэлцэх шүүх хуралдаанд шүүгч Г.Банзрагч 7, М.Батсуурь 7, Х.Батсүрэн 6, П.Соёл-Эрдэнэ 7, Ц.Цогт 4, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа 3, Д.Батбаатар 1 удаа оролцсоноос:

Шүүгч П.Соёл-Эрдэнэ 4, М.Батсуурь 2, Г.Банзрагч 1 хэргийн шүүх хуралдааныг даргалж; Шүүгч Г.Банзрагч 5, Х.Батсүрэн 4, М.Батсуурь 4, Ц.Цогт 3, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа 3, П.Соёл-Эрдэнэ 2 хэргийн шүүх бүрэлдэхүүнд; Шүүгч Х.Батсүрэн 2, Г.Банзрагч 1, Д.Батбаатар 1, М.Батсуурь 1, П.Соёл-Эрдэнэ 1, Ц.Цогт 1 хэрэг илтгэсэн байна.

Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын дээд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг сугалаагаар томилох журам”-ын 5.3-т заасны дагуу Эрүү, Иргэний хэргийн танхимын бүрэлдэхүүнд шүүгч П.Соёл-



Эрдэнэ **66**, Д.Батбаатар **27**, М.Батсуурь **2**, Х.Батсүрэн **1**, Ц.Цогт **1** гомдлыг тус тус хянан хэлэлцэх бүрэлдэхүүнд орсон байна.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **138** хэргийн **27.5** хувь буюу **38** итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **39.1** хувь буюу **54** нэхэмжлэгчийн, **11** хувь буюу **15** өмгөөлөгчийн, **13** хувь буюу **18** хариуцагчийн, **9.4** хувь буюу **13** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцсэн **138** хэргийн нэхэмжлэгч талаас гаргасан **16.7** хувь буюу **23** гомдлыг, хариуцагч талаас гаргасан **6.5** хувь буюу **9** гомдлыг, гуравдагч этгээд талаас гаргасан **2.9** хувь буюу **4** гомдлыг тус тус хангаж, нэхэмжлэгч талаас гаргасан **24** хувь буюу **33** гомдлын, хариуцагч талаас гаргасан **10.1** хувь буюу **14** гомдлын, гуравдагч этгээд талаас гаргасан **2.9** хувь буюу **4** гомдлын зарим хэсгийг тус тус хангаж, нэхэмжлэгч талаас гаргасан **21** хувь буюу **29** гомдлыг, хариуцагч талаас гаргасан **13** хувь буюу **18** гомдлыг, гуравдагч этгээд талаас гаргасан **2.9** хувь буюу **4** гомдлыг тус тус хангахгүй орхиж шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **138** хэргийг эрх зүйн төрлөөр нь авч үзвэл: газрын маргаан **27**, татварын маргаан **25**, төрийн албаны маргаан **17**, тендерийн маргаан **6**, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой маргаан **6**, зөрчлийн маргаан **5**, иргэний улсын бүртгэлийн маргаан **4**, хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн маргаан **4**, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн маргаан **4**, барилгын ажлын тусгай зөвшөөрлийн маргаан **2**, нийтийн эрх ашгийн маргаан **2**, гэрээний маргаан **2**, гаалийн маргаан **1**, нийгмийн даатгалын маргаан **1**, орон сууц хувьчлалын маргаан **1**, оюуны өмчийн маргаан **1**, төрийн хяналт шалгалтын маргаан **1**, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой маргаан **1**, давж заалдах журмаар **18**, хэм хэмжээний акттай холбоотой **10** хэргийг тус тус хянан шийдвэрлэжээ.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **26,886,600** (хорин зургаан сая найман зуун наян зургаан мянга зургаан зуу) төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **19,234,800** (арван есөн сая хоёр зуун гучин дөрвөн мянга найман зуу) төгрөгийг буцаан олгожээ. Захиргааны хэргийн танхим нь **42** албан бичиг (Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **9**, шүүгч Д.Батбаатар **8**, Х.Батсүрэн **7**, шүүгч Ц.Цогт **6**, П.Соёл-Эрдэнэ **5**, М.Батсуурь **4**, Г.Банзрагч **3**), **21** өргөдөл (Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **4**, шүүгч Г.Банзрагч **4**, М.Батсуурь **3**, Х.Батсүрэн **3**, Ц.Цогт **3**, Д.Батбаатар **2**, шүүгч П.Соёл-Эрдэнэ **2**) тус тус хүлээн авч, танхимын нийт шүүгчийн хуралдаанд танилцуулж, хариу өгчээ.

Улс төрийн намын бүртгэл хөтлөх журамд заасны дагуу **33** өргөдөл хүлээн авч, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар **21** өргөдлийг хэлэлцүүлж, танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **12** өргөдлийг хэлэлцэн буцаасан байна.

Тайлангийн хугацаанд шүүгчийн захирамж **55** гарснаас “хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай” **27**, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **28**;

Шүүхийн тогтоол **43** гарснаас “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **27**, “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлт шийдвэрлэсэн” **7**, “шүүгчээс татгалзсан хүсэлтийг шийдвэрлэсэн”

5, “хяналтын тогтоолд засвар оруулах тухай” 1, “нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон” 1 тогтоол, “нэхэмжлэгч, хариуцагчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон” 1, “хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, гомдол гаргаагүйд тооцох” 1 тус тус гаргажээ.

Танхимын нийт шүүгчийн хуралдааны тогтоол 489 гарснаас, “хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тухай” 359, “хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай” 111, “хяналтын журмаар гомдол гаргах хугацаа хэтэрснийг буцаах тухай” 7, “хуралдаан хойшлуулах тухай” 7, “хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, гомдол гаргаагүйд тооцох” 2, “хэргийн харьяалал тогтоох тухай” 1, “тогтоолд залруулга оруулах тухай” 1, “хэлэлцүүлэх тогтоолыг хэвээр үлдээх тухай” 1 тогтоол тус тус гарчээ.

Тайлангийн хугацаанд тусгай санал 5 гаргаснаас:

Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг тайлбарлан хэрэглэх”,

“Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэлтэй захиргааны хэргийг шийдвэрлэхэд “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх” эрх зүйн агуулга, нөхцөлт шинжийг шүүхээс тодорхойлох шаардлага, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтуудыг маргааны үйл баримтад холбогдуулан хэрэглэх талаар”;

Шүүгч Г.Банзрагч “Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлан хэрэглэх тухай”,

““Нийтийн эрх ашгийг хамгаалах”-тай холбоотой захиргааны хэрэгт “харьцангуй байх” зарчмыг тайлбарлан хэрэглэх тухай”;

Шүүгч Д.Батбаатар, М.Батсуурь нар ““Тогтворжуулалтын гэрчилгээ” бүхий хуулийн этгээдээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан Хөрөнгө оруулалтын тухай болон Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтыг тайлбарлан хэрэглэх” талаар тус тус бичиж, Улсын дээд шүүхийн цахим хуудаст байршуулсан.

Шүүхийн шийдвэрийн хураангуй 5 гаргаснаас:

Шүүгч М.Батсуурь “Нэг зөрчилд давхар хариуцлага хүлээлгэхгүй байх (NON BIS IN IDEM) зарчим татварын эрх зүйд үйлчилнэ”;

Шүүгч П.Соёл-Эрдэнэ “Төрийн албанд шатлан дэвших, чадахуйн зарчим”, “Иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн гэж торгож байгаа нь буруу”,

“Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөр авах журмыг батлан гаргахдаа хэлэлцүүлэг хийх байжээ”;

Шүүгч Ц.Цогт “Газар эзэмших эрх дуусгавар болоход уг газрыг Засаг даргын мэдэлд хүлээлгэн өгөх үүрэгтэй” талаар тус тус бичиж, Улсын дээд шүүхийн цахим хуудаст байршуулсан байна.

## 1.4. САХИЛГЫН ХЭРЭГ

Иргэний хэргийн танхимаас Сахилгын хэргийн шүүх хуралдаанд танхимын тэргүүн Г.Алтанчимэг **1**, шүүгч Н.Баярмаа **1**, П.Золзаяа **1**, Д.Цолмон **1**, хэргийн бүрэлдэхүүнд **оролцож**, Шүүгч Н.Баярмаа **1** хуралдааныг **даргалж**, Шүүгч Н.Баярмаа **1** хэргийг **илтгэсэн** байна.

Сахилгын хэрэг шийдвэрлэсэн байдал


Зураг 16



Захиргааны хэргийн танхимаас сахилгын хэргийн шүүх хуралдаанд шүүгч Г.Банзрагч **2**, М.Батсуурь **2**, Ц.Цогт **2**, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **1**, шүүгч Д.Батбаатар **1**, П.Соёл-Эрдэнэ **1** хэргийн бүрэлдэхүүнд **оролцож**, Шүүгч Г.Банзрагч **1** хуралдааныг **даргалж**; Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **1**, шүүгч Д.Батбаатар **1**, П.Соёл-Эрдэнэ **1**, Ц.Цогт **1** хэргийг тус тус **илтгэсэн** байна.

Сахилгын хэрэг шийдвэрлэсэн байдал

Зураг 17



Эрүүгийн хэргийн танхимаас Сахилгын хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **1**, шүүгч Б.Амарбаясгалан **1**, С.Батдэлгэр **2**, М.Пүрэвсүрэн **2**, Б.Цогт **2** хэргийн бүрэлдэхүүнд **оролцож**, Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ **1** хуралдааныг **даргалж**, **1** хэргийг тус тус **илтгэсэн** байна.

### Сахилгын хэрэг шийдвэрлэсэн байдал

Зураг 18



## 2.ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖИЛ:

### 2.1.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

2024 оны бүтэн жилд Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, шүүгчид дангаараа болон хамтарч шүүн таслах ажиллагаанаас бусад **147** ажлыг гүйцэтгэсэн байна.

Шүүн таслах ажиллагаанаас бусад ажлын хүрээнд боловсруулсан баримт бичиг-10, бичсэн ном гарын авлага-4, Мэргэшсэн чиглэлийн дагуу заасан хичээл-3, Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг-23, Ажлын хэсгийн оролцоо-13, Гадаад хурал, зөвлөгөөн, илтгэл, албан томилолт-13, Хууль тайлбарлах санал, тогтоолын төсөл боловсруулах, батлуулах-2, Шүүн таслах ажиллагааны талаар тойм, хураангуй гаргах ажил-9, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, аргачлал болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төслийн талаар санал боловсруулахад оролцох ажил-16, Нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчдийн зөвлөгөөн, Танхимын нийт шүүгчийн хуралдаанд оролцох ажил-6, Шүүхийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад асуудлын талаар танилцуулга, санал бэлтгэхэд оролцох ажил-14, Танхимын тэргүүний шүүн таслах ажиллагаанаас бусад ажлын зохист ачааллыг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 18, 28 дугаар зүйлд заасан бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийсэн ажил-1, Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг ахлан ажилласан тоо -3, Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажилласан тоо-10, Хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан тоо-2, Байгууллагаас санаачилсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, контент санаачлах, контент хийхэд оролцсон тоо-3, Монгол Улсад зохион байгуулагдсан Олон улсын эрдэм шинжилгээний хуралд мэргэжлийн чиглэлээр оролцож илтгэл хэлэлцүүлсэн тоо-6, Монгол Улсад зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хуралд мэргэжлийн чиглэлээр оролцож илтгэл хэлэлцүүлсэн тоо-2, Мэргэжлийн чиглэлээр дотоодын сэтгүүлд өгүүлэл бичиж нийтлүүлсэн өгүүллийн тоо-1, Шүүгч байгууллагын захиалгаар бичсэн ном, гарын авлагын тоо-6 ажлыг тус тус хийсэн байна.

#### Боловсруулсан баримт бичиг:

Хүснэгт 1

| № | Хариуцан гүйцэтгэсэн ажил                                                                                                                                                                | Шүүгчийн нэр                                                                    |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------|
| 1 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, саналыг нэгтгэх | Танхимын тэргүүн<br>Ч.Хосбаяр<br>Б.Амарбаясгалан                                |
| 2 | Станбулын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторингийн арга хэмжээнд санал боловсруулж, хүргүүлсэн.                                                       |                                                                                 |
| 3 | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.6 дугаар зүйлийг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбарын төсөл                                                                        | С.Соёмбо-Эрдэнэ,<br>Б.Амарбаясгалан,<br>С.Батдэлгэр,<br>М.Пүрэвсүрэн,<br>Б.Цогт |
| 4 | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7 дугаар зүйлийг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбарын төсөл                                                                        | С.Соёмбо-Эрдэнэ,<br>Б.Амарбаясгалан,<br>С.Батдэлгэр,<br>М.Пүрэвсүрэн,<br>Б.Цогт |

|    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                             |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------|
| 5  | Шүүхийг үл хүндэтгэх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн холбогдох заалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, 2024.04.25-ны өдөр Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, хууль санаачлагчид хүргүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                          | Б.Батцэрэн                  |
| 6  | 2024.05.03-ны өдөр “Эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдвээр Улсын дээд шүүхийн шүүгч нарт танилцуулга хийсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                             |
| 7  | Эрүүгийн хэргийн шийдвэр гардуулах, танилцуулах харилцааг зохицуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 36.13 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 39.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 40.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт тус тус заасныг нэг мөр зөв ойлгож, хэрэглэх талаар Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарын төслийг боловсруулж, 2023.07.03-ны өдөр нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, энэ талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын дээд шүүхийн саналыг 2024.02.18-ны өдөр хууль санаачлагчид хүргүүлсэн. |                             |
| 8  | Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захиалгаар шүүгч С.Өмирбектэй хамтран “Шүүхийг үл хүндэтгэх зөрчилд хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Б.Батцэрэн                  |
| 9  | 2024.05.07-ны өдөр Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар Улсын дээд шүүхээс өгөх саналын төслийг боловсруулж, хууль санаачлагчид хүргүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Б.Батцэрэн,<br>М.Пүрэвсүрэн |
| 10 | МУ-ын Үндсэн хуулийн цэцээс ирүүлсэн “Улсын Их Хурлаас 2020.01.10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийг нэмэлтээр оруулсан хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн” гэх мэдээлэлтэй холбоотой баримт бичгийг боловсруулан хүргүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                           | С.Соёмбо-Эрдэнэ             |

#### Бичсэн ном, гарын авлага:

Хүснэгт 2

| № | Хариуцан гүйцэтгэсэн ажил                                                                                                      | Шүүгчийн нэр                                 |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|
| 1 | Авлигын эсрэг олон улсын гэрээг Монгол Улсын эрүүгийн шүүхэд хэрэглэх онол, арга зүйн үндсэн асуудал сэдэвт докторын диссертац | Танхимын тэргүүн<br>Ч.Хосбаяр                |
| 2 | Олон улсын гэрээг тайлбарлах аргачилсан журам, зөвлөмжийн гарын авлагыг боловсруулсан. 2024.                                   |                                              |
| 3 | Мөрдөгч, прокурор нарт зориулсан “Хөрөнгө буцаах” сэдвээр гарын авлага боловсруулахад зөвлөхөөр оролцсон.                      | Танхимын тэргүүн<br>Ч.Хосбаяр,<br>Б.Батцэрэн |
| 4 | 2024 оны хуульчийн мэргэжлийн шалгалтын жишиг сорилгын хураамжийг хянан тохиолдуулсан.                                         | Б.Амарбаясгалан                              |

#### Мэргэшсэн чиглэлийн дагуу заасан хичээл:

Хүснэгт 3

| № | Хариуцан гүйцэтгэсэн ажил                                                                                          | Шүүгчийн нэр                  |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|
| 1 | 2024.05.17-ны өдөр Авлигатай тэмцэх газарт “Авлига мөнгө угаах гэмт хэргийн нэгдэн шалгах ажиллагааны явцад нотлох | Танхимын тэргүүн<br>Ч.Хосбаяр |

|   |                                                                                                                                                               |            |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
|   | баримт цуглуулах бэхжүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт хичээлийг орсон.                                                                                        |            |
| 2 | 2024.06.06-ны өдөр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутнуудын төлөөллийг хүлээн авах арга хэмжээнд оролцож, асуултад хариулж, практикийн ерөнхий мэдлэг олгов. |            |
| 3 | 2024.03.05-ны өдөр шинээр томилогдсон шүүгч нарт “Мэтгэлцэх зарчим”, “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр тус тус хичээл заасан.  | Б.Батцэрэн |

### Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг:

Хүснэгт 4

| №  | Хариуцан гүйцэтгэсэн ажил                                                                                                                                                                                                                                                                                                                           | Шүүгчийн нэр                                                                      |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------|
| 1  | Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хорооны ээлжит хуралдаанд тухай бүр оролцож, “Шүүхийг үл хүндэтгэх зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалтын хөтөлбөрийг танилцуулж, батлуулав.                                                                                                 | Танхимын тэргүүн Ч.Хосбаяр                                                        |
| 2  | 2024.02.28-ны өдөр Монголын хуульчдын холбооноос зохион байгуулсан “Эрүүгийн эрх зүйн шинэтгэл” сэдэвт хэлэлцүүлэгт “Эрүүгийн хуулийн хэрэглээ ба онол” сэдвийг хэлэлцүүлж, панелистаар ажиллав.                                                                                                                                                    |                                                                                   |
| 3  | 2024.03.01-ний өдөр УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатарыг хүлээн авч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь зарим асуудлыг боловсронгуй болгох талаар санал солилцов.                                                                                                                                             |                                                                                   |
| 4  | АТГ-аас 2024.03.04-нөөс 07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Буцаан авсан хөрөнгө” сэдэвт бага хуралд оролцов.                                                                                                                                                                                                                                      |                                                                                   |
| 5  | 2024.05.14-ний өдөр АНУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Майкл Буангантай хийсэн уулзалтад оролцов.                                                                                                                                                                                                                                               |                                                                                   |
| 6  | 2024.05.16-ны өдөр Ерөнхий шүүгч Д.Ганзориг АНУ-ын Жо Спурликийн сангийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалтад оролцож, цаашдын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.                                                                                                                                                                   |                                                                                   |
| 7  | 2024.03.11-ний өдөр Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх төслийн хүрээнд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /ОУЭЗХБ/-ын төлөөллийг хүлээн авч уулзав.                                                                                                                                                | Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Б.Батцэрэн                                            |
| 8  | 2024.03.27-ны өдөр Захиргааны хэргийн танхимаас зохион байгуулсан “Процессын нээлттэй байдал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцов.                                                                                                                                                                                                                          | Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт |
| 9  | 2024.03.28-ны өдөр Хуульчдын холбоо, АНУ-ын Элчийн сайдын яамнаас зохион байгуулсан “Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудал” хэлэлцүүлэгт оролцов.                                                                                                                                                                                                 | Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, М.Пүрэвсүрэн                                          |
| 10 | 2024.04.12-ны өдөр Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч, багш нартай уулзаж, Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд заасан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэргийн шийдвэрлэлт, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцов. | Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Б.Батцэрэн                                            |



|    |                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                               |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|
| 11 | 2024.06.04-ний өдөр Захиргааны хэргийн танхимаас зохион байгуулсан Монгол Улсад Захиргааны хэргийн шүүх байгуулагдсаны 20 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцов.                                                                                                   | Танхимын тэргүүн<br>Ч.Хосбаяр,<br>С.Батдэлгэр,<br>С.Соёмбо-Эрдэнэ,<br>М.Пүрэвсүрэн,<br>Б.Цогт |
| 12 | 2024.06.06-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого: Оролцоо хамтын ажиллагаа” сэдэвт хүндэтгэлийн арга хэмжээнд оролцов                                                                                                            | Танхимын тэргүүн<br>Ч.Хосбаяр,<br>С.Соёмбо-Эрдэнэ                                             |
Монгол Улсын дээд шүүх нь Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлээр “хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох, Улсын дээд шүүхийн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг томилох, шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг гаргах, хууль тогтоомжийн төслийн талаарх саналаа хууль санаачлагчид хүргүүлэх зэрэг бүрэн эрхийг хамааруулсан.

Дээрх бүрэн эрхийг Нийт шүүгчийн хуралдаанаар хэрэгжүүлдэг бөгөөд 2024 оны бүтэн жилийн байдлаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан 11 удаа товлогдож 33 асуудлыг, Шүүгчдийн зөвлөгөөн 9 удаа товлогдож 13 асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд Хуралдаан, Зөвлөгөөний зохион байгуулалт болон тасралтгүй, хэвийн явуулах бэлтгэл ажлыг хариуцан хангаж ажиллалаа.



Хуулийг зөв хэрэглэх талаар Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас гаргасан албан ёсны тайлбарууд:

Хүснэгт 35

| №  | Тогтоолын нэр                                                                                                                                              | Тогтоолын он, сар, өдөр | Дугаар |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|--------|
| 1. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7, дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай,                                                  | 2024.06.20              | 21     |
| 2. | Иргэн болон захиргааны хэргийн харьяаллыг зааглан ялгахтай холбоотой ИХШХШ тухай хууль болон ЗХШХШ тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг тайлбарлах тухай. | 2024.06.20              | 25     |

Монгол Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнөөр баталсан журам, аргачлал:

Хүснэгт 36

| №  | Журмын нэр                                                                                                                                                                                                                                | Журмын он, сар, өдөр | Дугаар |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|--------|
| 1. | Монгол Улсын дээд шүүхийн танхимын нийт шүүгчийн хуралдааны журамд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхэд бэлтгэх журамд өөрчлөлт оруулах тухай,                   | 2024.02.23           | 05     |
| 2. | Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам /шинэчилсэн найруулга/-ын төслийг танилцуулж, батлуулах,                                                                                                                                            | 2024.02.23           | 06     |
| 3. | Улс төрийн намын бүртгэл хөтлөх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,                                                                                                                                                                    | 2024.03.21           | 10     |
| 4. | Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гаргах нэхэмжлэл, хариу тайлбарын загвар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг батлах тухай (ИХШХШ тухай хуулийн 75 <sup>3</sup> дугаар зүйлийн 75 <sup>3.3</sup> ), | 2024.06.20           | 23     |
| 5. | Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, магадлалын бүтэц боловсруулах аргачлалыг батлах тухай (ИХШХШ тухай хуулийн 759 дүгээр зүйлийн 759.4),                                                                      | 2024.06.20           | 24     |

|    |                                                                                                                               |            |    |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|----|
| 6. | Нийт шүүгчийн хуралдаанаар батлагдсан “Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны маягтад” өөрчлөлт оруулах тухай. | 2024.10.28 | 27 |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|----|

Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэгдэж хууль санаачлагчид хүргүүлсэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналууд:

Хүснэгт 37

| №                                                                                                                         | Тогтоолын нэр                                                                                                                                                                                         | Тогтоолын он, сар, өдөр | Дугаар |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|--------|
| <b>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомж</b> |                                                                                                                                                                                                       |                         |        |
| 1.                                                                                                                        | Хууль зүй дотоод хэргийн сайдаас ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,                                                                  | 2024.05.07              | 18     |
| 2.                                                                                                                        | Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн шүүхийн үйл ажиллагааны олон нийтэд ил тодорхой, нээлттэй байхыг хангахтай холбогдуулан Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн танилцуулга, | 2024.05.07              | 19     |
| 3.                                                                                                                        | Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,                                                  | 2024.06.20              | 22     |
| 4.                                                                                                                        | Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригоос ирүүлсэн Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,                                                                           | 2024.10.28              | 26     |
| 5.                                                                                                                        | Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.                                                                 | 2024.10.30              | 28     |
| <b>Бусад хууль тогтоомж</b>                                                                                               |                                                                                                                                                                                                       |                         |        |
| 6.                                                                                                                        | Зарим хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар хууль санаачлагчид санал хүргүүлэх тухай,                                                                                                          | 2024.02.23              | 07     |
| 7.                                                                                                                        | Шүүхийг үл хүндэтгэх зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хууль санаачлагчид хүргүүлэх тухай,                                        | 2024.04.25              | 16     |
| 8.                                                                                                                        | Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох саналыг хууль санаачлагчид уламжлах тухай.                                                                             | 2024.11.22              | 30     |

Мөн Нийт шүүгчийн хуралдаанаар улс төрийн намуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлт 14, бусад 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, иргэдээс Ерөнхий шүүгч болон Улсын дээд шүүхэд хандаж ирүүлсэн нийт 674 өргөдөл, хүсэлт, гомдлыг хүлээн авч, зохих журмын дагуу холбогдох Танхим, нэгжид нэн даруй шилжүүлж, хариу өгөх шаардлагатай тохиолдолд 10 хоногт багтаан хариуг өгч шийдвэрлэсэн байна.

### Гадаад харилцааны хүрээнд:

Монгол Улсын шүүх, шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг хангах, шүүн таслах ажиллагаа, дэлхий нийтэд шинэ тутам үүсэж байгаа гэмт хэргийн судалгаа, шийдвэрлэлтийн туршлага солилцох болон шүүхийн захиргааны ажилтныг чадавхжуулах зорилгоор гадаад харилцааг өргөжүүлэн уулзалт, сургалтад хамруулахаас гадна холбогдох олон улсын бусад байгууллагатай хоёр талт гэрээ хэлэлцээр, Санамж бичиг байгуулах зэрэг ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Тухайлбал:

Хүснэгт 38

| № | Ерөнхий шүүгчийн оролцсон уулзалт, хэлэлцээрүүд:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй шүүгч, ажилтны төлөөлөл 2024 оны 03 дугаар сарын 06-наас 13-ны өдрүүдэд Нидерландын Хаант Улсын Гааг хотод зохион байгуулагдсан Олон Улсын Эрүүгийн Шүүхийн шүүгчийн тангараг өргөх ёслолд оролцсон бөгөөд олон улсын бусад байгууллагуудтай хамтран ажиллах туршлага солилцох зорилго бүхий хоёр талт уулзалт;                                                                                                                                                                                                                  |
| 2 | Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар нь 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Бүгд Найрамдах Узбекистан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Б.Д.Исламов, шүүгч Т.М.Санобар бусад төлөөлөгчидтэй, мөн 2024 оны 4 дугаар сарын 03 -ны өдөр БНКУ-ын дээд шүүхийн Ерөнхий шүүгч А.А.Мергалиев, БНКУ-ын шүүхийн тамгын газрын дарга Н.Р.Ахметзакиров болон бусад төлөөлөгчидтэй тус тус хоёр орны шүүхүүдийн хамтын ажиллагааны талаарх цахим уулзалт; |
| 3 | Ерөнхий шүүгч Д.Ганзориг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Канад Улсын холбооны шүүхийн асуудал эрхлэх газрын Олон улсын хөтөлбөр хариуцсан газрын дарга О.Шаков, 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Майкл Буанганыг, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр АНУ-ын Жо Спурликийн сангийн төлөөлөгчдийг хүлээн авч цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон болно.                                                                                                                                                 |
| 4 | Ерөнхий шүүгч Д.Ганзориг, шүүгч Ц.Цогт нар Малайз Улсын Куала Лумпур хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн орнуудын Ерөнхий шүүгчдийн 19 дүгээр хуралд 2024 оны 10 дугаар сарын 10-аас 15-ны өдрүүдэд оролцсон.                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| 5 | Ерөнхий шүүгч Д.Ганзориг Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд Ина Марчюлөнитег 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хүлээн авч уулзалт.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |

### Дотоод аудитын үйл ажиллагааны чиглэлээр:

Дотоод аудитын 2024 оны жилийн төлөвлөгөөг боловсруулан Ерөнхий шүүгчийн захирамжаар батлуулан, төлөвлөгөөний дагуу удирдамж гарган гүйцэтгэлийг хэрэгжүүлэн ажиллаж хагас жилийн тайлангаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг хариуцсан газарт хуулийнх хугацаанд нь хүргүүлсэн.

Монгол Улсын дээд шүүхийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн хүрээнд III улирлын байдлаар шилэн дансны хөтлөлт, хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээгийн албанаас үнэлгээ хийж, зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаа.

#### 4.МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Тамгын газар нь Улсын дээд шүүхийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах, дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдал болон судалгаа, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүхийн захиргааны менежментийг боловсронгуй болгох зорилгоор Төсвийн ерөнхийлөн захирагчаар гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан ажиллаж 2024 онд 99.7 хувийн гүйцэтгэлийн биелэлттэй гарлаа.

##### 4.1.ЗАХИРГАА УДИРДЛАГА

“Монгол Улсын дээд шүүхийн 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн нэмэгдүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, шүүн таслах ажиллагааг нээлттэй, ил тод явуулах, шүүх бие даасан, шүүгч хараат бусаар үйл ажиллагаагаа явуулж шийдвэрээ гаргадаг байх зэрэг зарчмын асуудлуудыг багтааж, шүүхийн үйл ажиллагааны үр нөлөө, шүүгч, ажилтны мэргэжил, ур чадварыг ахиулж хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлд нэгтгэн боловсруулж Нийт шүүгчийн хуралдаанаар батлав.

Монгол Улсын дээд шүүхийн 2023 оны жилийн тайлангийн хураангуйг шинээр боловсруулж хэвлэмэл танилцуулга болгон гаргалаа.

Зураг 21



“Албан хэрэг хөтлөлтийн журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журам”, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” тус тус баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын баримт бичгийн стандартыг мөрдүүлэн ажиллах үүднээс “Хэвлэмэл хуудасны нэр төрөл, индекс”-ийг шинэчлэв. Холбогдох журам, стандартад нийцүүлэн улсын байцаагчаар хянан баталгаажуулсан 32 нэр төрлийн хэвлэмэл хуудасны эхийг Архивын Ерөнхий газрын зөвшөөрлөөр үндэсний монгол бичгээр бэлтгэж, баталгаажуулсан.



Байгууллагын баримт нягтлан шалгах комиссын хуралдааныг хагас жил тутам хуралдуулж, Байгууллагын 2024 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” батлах, Улсын дээд шүүхийн архивд байгаа 1996-2012 оны байнга хадгалах 1039 хадгаламжийн нэгжид техник чанарын үзлэг хийж гүйцэтгэв.

**Хүлээн авсан албан бичиг, өргөдөл, гомдол, явуулсан бичиг:**

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас тайлант хугацаанд Тамгын газарт 402 өргөдөл гомдол, 1112 албан бичиг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, эрх бүхий албан тушаалтанд танилцуулсны дагуу холбогдох шүүгч, ажилтнуудад тухай бүр шилжүүлэн өгч шийдвэрлүүлснээс гадна 6055 албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлжээ.

Зураг 22



2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвшигч нарт лавлагаа (2024.05.20-ноос 2024.06.03-ны өдрийг дуустал 1613 иргэнд) олгож ажиллалаа.

Зураг 23



Улсын Ерөнхий Прокурорын газраас прокурорын дүгнэлт бичиж ирүүлсэн нийт 16 цагаатгалын хэрэг хүлээн авч, үүнээс 17 хэлмэгдэгчид холбогдох 12 хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж, 4 хэргийг прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож шийдсэн байна. Цагаатгалын бүртгэлд 17 хэлмэгдэгчийн мэдээллийг шинээр оруулж, мөн нийт 2 хэлмэгдэгчдийн мэдээллийг нөхөн хөтлөв.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас 2024 онд иргэн, хуулийн этгээдтэй Ажил гүйцэтгэх гэрээ-21, Худалдах, худалдан авах гэрээ-10, Үйлчилгээ үзүүлэх гэрээ-9, Тендерийн гэрээ-8, Сургалтын гэрээ-3, Зөвлөх үйлчилгээний гэрээ-3, Бусад төрийн 34 гэрээ нийт 88 гэрээ байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын гэрээний төсөл болох “Ажил гүйцэтгэх гэрээ”, “Худалдах, худалдан авах гэрээ”-ний төсөл, гэрээн дүгнэх актын төслийг тус тус шинэчилсэн мөн 2024 онд гүйцэтгэл дутуу гэрээ байхгүй бөгөөд 2024-2025 он дамжин хэрэгжих 20 гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

#### **Архивын чиглэлээр:**

2024 онд Тамгын газрын Байнгын хадгаламжийн нэгж-236, Түр хадгаламжийн нэгж-141, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж-5 нийт 382 баримтыг шинээр цахимжуулав.

2013-2023 оны 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн баримтад төвлөрүүлэн хадгалж байсан баримтуудыг “Байнга”, “Түр” болон “70 жил” хадгалах хадгаламжийн нэгжид төрөлжүүлэн ангилалт хийлээ. Үүнд:

- Байнга хадгалах хадгаламжийн нэгжид “Байгууллагын татварын ТТ-11 тайлан” 11 хадгаламжийн нэгж;
- Байнгын хадгалах хадгаламжийн нэгжид “Байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн НД-7 тайлан” 11 хадгаламжийн нэгж;
- 70 жил хадгалах хадгаламжийн нэгжид “Цалингийн тооцооны дэлгэрэнгүй хүснэгт” 10 хадгаламжийн нэгж;
- 70 жил хадгалах хадгаламжийн нэгжид “Ажилчдын Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн НД-8 тайлан” 11 хадгаламжийн нэгж болгон тус тус салгаж төрөлжүүлэв.

Үндэсний төв архивд шилжүүлэх Монгол Улсын дээд шүүхийн 1996-2012 оны байнга хадгалах 1039 хадгаламжийн нэгжид техник чанарын үзлэг хийж тус бүрд товьёг, баталгааны хуудас болон ашиглалтын хуудас хийж шинээр үдэж хавтаслан бэлтгээд байна.

#### **Хүний нөөцийн, сургалтын үйл ажиллагааны хүрээнд**

“Хяналтын шатны шүүхийн шүүгчийн ажлын зохист ачааллыг тогтоох, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журам”, “Шүүгч, албан хаагчдын орон сууцны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журам”-уудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хэлтэс, нэгжийн чиг үүргийн шинжилгээ хийж, төрийн захиргааны 123 албан тушаалтанд хамаарах 43 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагаас батлах зөвшөөрөл авсны дагуу Тамгын газрын 238 төрийн албан хаагчид хамаарах албан тушаалын тодорхойлолтуудыг батлуулав.

Шилжүүлэн томилсон 12, шинээр томилсон 40 албан хаагчийн хувийн хэргийг шинээр баяжуулж, 128 албан хаагчийн хувийн хэргийн мэдээллийг шинэчилсэн байна.



### Албан хаагчдад чиглэсэн хөтөлбөрүүдийн хүрээнд

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт 22 шүүгч, 116 албан хаагчийг хамрууллаа.

Зураг 24



Монгол Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай Нийслэлийн ерөнхий боловсролын 115, 29, 33 дугаар сургууль, Шинэ Монгол сургуулийн сурагчид, МУИС-ын ХЗС болон БНСУ-ын Күүминий ИС-ийн оюутнууд танилцах аялал хийж, Монгол Улсын дээд шүүхийн шүүгч нартай уулзалт ярилцлагыг зохион байгууллаа.

Зураг 25



## Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх зорилтот сургалтын чиглэлээр


Төрийн албаны сургалтын төв байгууллагаас зохион байгуулдаг төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалт, ахлах, эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад 14 албан хаагч хамрагдсан байна.

Мөн Удирдлагын академийн танхимаар зохион байгуулсан “Шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих аргачлал боловсруулах нь” сэдэвт богино хугацааны төлөвлөгөөт сургалтад албан хаагчдыг хамруулсан.

Монголын хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан Хуульчийн үргэлжилсэн сургалтын 2024 оны 2-4 багц цагийг тооцуулав.

Зураг 26

### 2024 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАН ХЭРЭГЖҮҮЛСЭН СУРГАЛТУУД:



### Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах чиглэлээр


Монгол Улсын шүүхийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх” асуудлыг нарийвчлан зохицуулсан бөгөөд хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг сонирхогч этгээд биечлэн болон цахимаар танилцах боломжийг бүрдүүлсэн.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр хуулийн хүрээнд шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэхээр харилцааг тухайлан тусгасан. Шүүх хуралдааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар олон нийт үнэн бодит мэдээллийг авах боломжийг тэгш хангахад шүүхэд цахим архив, систем, платформыг хөгжүүлэх талаар мөн тусгасан.

## Шүүх хуралдааны шууд дамжуулалт

Шүүх хуралдааныг шууд дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор холбогдох судалгааны ажил болон нарийвчилсан зураглалыг гаргаж, төслийн санал боловсруулж шаардлагатай техник тоног төхөөрөмжийн жагсаалт болон худалдан авах ажиллагааг зохион байгуулав.

Зураг 27



Цахим шууд дамжуулалтын тоног төхөөрөмжийг нээлттэй тендер шалгаруулалтаар шалгаруулж, шууд дамжуулалтын дуу дүрсийг холих, цахим хуудас руу дамжуулах төхөөрөмж, шууд дамжуулалтын бичлэгийг хадгалах төхөөрөмж, 16 хүртэлх сувагтай дижитал дууны холигч, хяналтын 4K телевиз, хөдөлгөөнт камер, микрофон хувиргагч, өндөр чанарын дуу, дүрс дамжуулах SDI кабель зэргийг авч Хяналтын шатны шүүх хуралдааныг байгууллагын дотоод сүлжээнд болон нээлттэй дамжуулах хөгжүүлэлт хийж, хур, дан системтэй холбож шаардлагатай сангуудыг сервер дээр суулгаж тохируулах ажлыг хийснээр шүүх хуралдааныг шууд дамжуулалтыг жигдрүүлэн ажиллаж байна.

Мөн өндөр нягтаршилтай 360 градус PTZ камер суурилуулж шүүгч болон их танхимд байгаа оролцогчийг нэгэн зэрэг харах боломж бүрдүүлэв.

Зураг 28





Монгол Улсын дээд шүүхийн supremecourt.mn веб сайт, Улсын дээд шүүхийн сошиал сувгуудаар мэдээ мэдээллийг түгээж, өнгөрсөн хугацаанд цахим сайтад 145 мэдээ, цахим хуудаснуудад нийт 440 контентыг нийтэлсэн байна.

Мөн дээрх хугацаан дахь хамгийн хандалт өндөр контентоор “Хууль гэж юу вэ?” нэвтрүүлгийн трейлер, Хөгжлийн банкны гэх тодотголтой хэргийн шүүх хуралдааны шууд дамжуулалт, мөн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны шууд дамжуулалтыг ДАН системээр бүртгүүлэн үзэх боломжтой болсон талаарх постер мэдээллүүд багтсан юм.

Нийт оруулсан мэдээ мэдээлэл, контентыг нийт 28.4 мянган удаа үзсэн байна. Хамгийн их хандалттай контентуудад хяналтын шатны захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны шууд дамжуулалтыг үзэх боломжтой талаарх постер мэдээ, шүүхийн шийдвэрийн тойм, “Хууль гэж юу вэ” нэвтрүүлэг, “Хүүхдүүд асууж байна” нэвтрүүлэг болон Хөгжлийн банктэй холбоотой мэдээлэл, мөн Улсын дээд шүүхтэй танилцахаар ирсэн хүүхдүүдийн талаарх мэдээлэл багтжээ.

Улсын дээд шүүхийн албан ёсны веб сайтын идэвхтэй хэрэглэгчдийн тоо сүүлийн 1 жилийн хугацаанд 105 мянга байна. Харин шинэ хэрэглэгчдийн тоо 98 мянга болжээ. Энэхүү үзүүлэлтийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад идэвхтэй хэрэглэгчдийн тоо 1.7, шинэ хэрэглэгчдийн тоо 1.6 дахин өссөн үзүүлэлттэй байгаа юм.

### Мэдээллийн аюулгүй байдал, технологийн ажлын хүрээнд

Улсын дээд шүүхийн цахим хуудасны өгөгдлийн сангийн засвар шинэчлэлт, өгөгдлийн сангийн хүснэгт хоорондын холбоосыг засварлаж, эх кодыг java хэлнээс python хэл рүү хөрвүүлэх ажлуудыг хийхийн сацуу “Хуулийн төсөлд санал авах”, “Улс төрийн намын дугаар үүсгэх”, шилэн дансны холболт, цагаатгалын бүртгэлийн үнэмлэх олгосон бүртгэл, нөхөн олговрын бүртгэлийн цэсүүдийг шинээр бий болгон хөгжүүлэв. Мөн Захиргааны хэргийн танхимын Хяналтын шатны шүүх хуралдааны зарын хэсэгт шинэчлэлт хийж, тойм оруулах төрөл гэх зэрэг шаардлагатай шинэчлэлтүүдийн нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгэв.


Улс төрийн намын бүртгэлийн программыг хөгжүүлэх ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа, холбооны яамтай ХУР системийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, сервис авах техникийн нөхцөлийг бүрдүүлж, ажлын даалгавар боловсруулан Улс төрийн намын бүртгэлийн программыг хөгжүүлж дуусгаад туршилтын нэвтрүүлэлт хийн ажиллаж байна.

Зураг 29

| <div>  <div> <b>МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ</b><br/>             УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ           </div> <div>   </div> </div> |                                                                                     |                                 |          |              |              |                |                                                                                                                                                                                                                                                                   |                        |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|---------------------------------|----------|--------------|--------------|----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|
| №                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Бэлгэдэл                                                                            | Намын нэр                       | Товч нэр | Регистрийн № | Бүртгэлийн № | Намын дарга    | Холбоо барих                                                                                                                                                                                                                                                      | УДШ бүртгэсэн огноо    |
| 1                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |  | Монгол Ардын нам                | МАН      | 8488908      | 8082001001   | Л. ОЮУН-ЭРДЭНЭ |    | 1990 оны 5-р сарын 16  |
| 2                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |  | Ардчилсан нам                   | АН       | 8488916      | 8082001002   | Л. ГАНТӨМӨР    |    | 2000 оны 12-р сарын 26 |
| 3                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |  | Монголын Ногоон нам             | МНН      | 8488924      | 8082001003   | О. БУМ-ЯЛАГЧ   |    | 1990 оны 5-р сарын 26  |
| 4                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |  | Иргэний зориг ногоон нам        | ИЗНН     | 8488932      | 8082001004   | Б. БАТБААТАР   |    | 2000 оны 3-р сарын 23  |
| 5                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |  | Монголын Уламжлалын Нэгдсэн нам | МУНН     | 8488959      | 8082001005   | Б. БАТБОЛД     |    | 1994 оны 1-р сарын 14  |

Аюулгүй байдлын өндөр түвшинд тест хийн хэрэг хуваарилах, шүүх бүрэлдэхүүн томилох, даргалагч томилох санамсаргүй байдлаар сонгох программ хөгжүүлж ашиглахад бэлэн болов.

Зураг 30



Байгууллагын албан хаагчдын дотоод хэрэгцээнд PGP-шифрийн алгоритм дээр суурилсан гар утаснаасаа болон ажлын компьютер дээрээ ашиглах дотоод харилцааны систем хөгжүүлж хэрэглээнд оруулсан, шаардлагатай тохиолдолд албан хаагчид дэлхийн аль ч улсаас өөрийн ажлын компьютерт хандаж ажиллах шийдлийг гаргаж, зайнаас ажиллах Tailscale программ зэрэг шийдлүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Мөн Фишинг сорил явуулах кибер аюулгүй байдлын программын туршилтыг хийж, сорил явуулж, defender болон fortigate төхөөрөмжүүдийн тусламжтай Улсын дээд шүүхийн сүлжээний болон цахим шуудангийн халдлагын тоо 50 хувиар буурууллаа.

Зураг 31



## 4.2.ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан (legalinfo.mn) дахь “Улсын дээд шүүхийн тогтоол” хэсэгт хууль тайлбарласан тогтоолын зөрүүг арилгаж, залруулга засварыг хийв.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбогдуулан “Эрх зүйн чадамжгүй этгээдийн мэдээллийн сан”-г 946 нэгж бүртгэлээр шинэчлэн бүрдүүлсэн байна.

2024 онд хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоолуудыг (shuukh.mn, supremecourt.mn) цахим санд хууль, журамд заасны дагуу байршуулан ажиллаж байгаагаас эрүүгийн 115, иргэний 253, захиргааны 114 тогтоол болж байна.

Зураг 32



Тайлант хугацаанд эрүүгийн 1003, иргэний 1572, захиргааны 520, сахилгын 3 нийт 3098 хэргийг хүлээн авсан байна.

Хяналтын шатны шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж, 714 шүүх хуралдаанд дэг сахиулан, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг ханган ажиллав.

Олны анхаарал татсан, олон холбогдогчтой, ээдрээ маргаантай хэрэгт цагдаагийн байгууллагыг оролцуулах, хамгаалалт авах ажиллагааг 4 удаа зохион байгууллаа.

Мөн хугацаанд “Эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал”, “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”, Эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажиллагааны мэдээний маягтын төсөлд оруулах саналыг тус тус нэгтгэн Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэв.

### Номын сан

Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид болон бүтцийн нэгжүүдээс 24 төрлийн ном, хэвлэлийн захиалгыг авч бүтэн жилийн байдлаар 24 нэр төрлийн 144 ном, гарын авлагаар номын санг баяжуулж, бүртгэлийн “Коха” цахим бүртгэлд бүртгэсэн ба одоогоор нийт номын санд монгол хэлээр 4029, гадаад хэлээр 2414 ном, нийт 6443 номтой болоод байна.


МУИС-ийн номын сантай хамтарч Монгол Улсын дээд шүүхээс тус номын санд өгсөн ном, сэтгүүлүүдээс эхний ээлжид “Монголын төр эрх зүй” сэтгүүлийн 1995-аас 2021 онд хэвлэгдсэн гарсан нийт ерэн дугаар, Улсын дээд шүүхийн тогтоолуудын 2004-2010 оны хэвлэлтүүд, Монголын шүүх-1, 2, 3-р ботиудыг цахим хэлбэрт оруулж, PDF файл болгон бэлтгээд байна.

### *Шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр*

“Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим систем ашиглах журам”-ыг баримтлан (live) 714 шүүх хуралдааны явцын мэдээллийг хэргийн оролцогч, иргэд олон нийтэд хүргэж, мэдээллээр хангасан байна.

Хяналтын шатны шүүх хуралдааны зар, тойм 742, танхимын нийт шүүгчийн хуралдааны зар, тойм 3015-ыг тус тус шүүхийн цахим хуудсаар мэдээллээ.

Зураг 33



Мөн хугацаанд хяналтын шатны шүүх хуралдаанд танхимаар 2126, цахимаар 227 оролцогч оролцжээ. Шүүх хуралдааны явцын дууны, дуу-дүрсний бичлэг давхардсан тоогоор 1467 хийгдэж баталгаажууллаа.

Шүүхийн шийдвэрээр гарсан (эрүүгийн) 92 мэдэгдэх хуудсыг Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт тус тус хугацаанд нь хүргүүлсэн. Улсын дээд шүүхийн цахим сайтад 11 шийдвэрийн тоймыг нийтлэв.

Хяналтын шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны улирал, хагас жилийн тайланг “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам”-ын дагуу шинэчлэгдсэн хураангуй маягтаар тогтоосон хугацаанд нь гаргаж, албан бичиг болон цахим хэлбэрээр Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын академид тус тус хүргүүллээ.

### **4.3.ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Шүүхийн гадаад харилцаа өргөжиж шүүгч, ажилтнууд бүс нутгийн, олон улсын чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны болон шүүхийн үйл ажиллагааны туршлага судлан ажиллаж байна.





**“Захиргааны эрх зүйн системчлэл, хэрэглээ: Харилцан хамаарал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа**

Монгол Улсын дээд шүүхээс “Захиргааны эрх зүйн системчлэл, хэрэглээ: Харилцан хамаарал” сэдвийн дор олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулав.



Олон улсын эрдэм шинжилгээний хуралд ХБНГУ, Канад, БНТУ, Сингапур, Япон, БНСУ зэрэг эрх зүйн систем өндөр хөгжсөн орнуудаас илтгэгч нар оролцсон юм. Тухайлбал, Оттавагийн их сургуулийн Захиргааны эрх зүй, засаглалын тэнхимийн эрхлэгч Проф. Др. Пол Дейли, Макс Планкийн харьцуулсан нийтийн эрх зүй, олон улсын эрх зүйн хүрээлэнгийн ахлах судлаач Проф. Др. Райнер Гроте,

Сөүлийн үндэсний их сургуулийн Хуулийн сургуулийн профессор Юн Санг Ри, ХБНГУ-ын Бавари муж улсын Захиргааны хэргийн шүүхийн Дэд ерөнхий шүүгч Мехтилд Клайн, Сингапурын менежментийн их сургуулийн профессор Южин Тан, Турк Улсын Шүүхийн академийн Стратегийн хөгжлийн тэнхимийн захиргааны шүүгч Ферхат Экер, Осакагийн их сургуулийн хүндэт профессор, Отемон Гакуин их сургуулийн Хууль зүйн факультетын профессор Такахаши Акио зэрэг олон улсын нэр хүнд бүхий эрдэмтэн, судлаач нар илтгэлээ толилуллаа.

Мөн, Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Улсын дээд шүүхийн шүүгч М.Батсуурь, Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч Др. П.Одгэрэл, Хүний эрхийн үндэсний комиссын дарга Д.Сүнжид, Улсын дээд шүүхийн Хэргийн хөдөлгөөн, мэдээлэл, судалгааны хэлтсийн шүүгчийн судлаач туслах-ахлах мэргэжилтэн А.Бодьбилэг, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн нар илтгэл тавьсан байна.

### *Гадаад хамтын ажиллагааны хүрээнд*

- Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч П.Золзаяа нар Япон улсын Хууль зүйн яамны Судалгааны нэгдсэн хүрээлэн (RTI)-ийн Олон улсын хамтын ажиллагааны газрын захирал Шинтаро Найто, профессор Кэйсүкэ Гото нарын төлөөлөгчдийг 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хүлээн авч, хамтын ажиллагааны асуудлаар;

- Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Иргэний хэргийн танхимын шүүгч Х.Эрдэнэсүвд, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /ОУЭЗХБ/-ын төлөөллийг хүлээн авч уулзаж, “Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл”-ийн үзэл баримтлалын асуудлаар;

- Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Ц.Цогт болон Д.Батбаатар, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга нар 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр АНУ-ын Аризона мужийн шүүхийн төлөөллүүдийг хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар;

- Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Д.Батбаатар болон Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр АНУ-ын Хууль зүйн яамны Гадаад дахь прокурорын сургалт, хөгжлийн төвийн бүс нутаг хариуцсан захирал хатагтай Еэ Тингийг хүлээн авч, хамтын ажиллагааны асуудлаар;

- Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Канад Улсын холбооны шүүхийн асуудал эрхлэх газрын Олон улсын хөтөлбөр хариуцсан газрын дарга О.Шаковыг хүлээн авч, хамтын ажиллагааны асуудлаар;

- Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Майкл Буанганыг хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар;

- 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Ерөнхий шүүгч Д.Ганзориг АНУ-ын Жо Спурликийн сангийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалтад оролцож, цаашдын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

- Монгол Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр тэргүүтэй төлөөлөгчид АНУ-ын Калифорния их сургуулийн профессор

хатагтай Мей Лин Спенсерийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар;

- Монгол Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа нар АНУ-ын Шүүхийн коллежийн ерөнхийлөгч Бенез Алданаг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар;

- Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Х.Эрдэнэсүвд, Н.Баярмаа нар Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-ны Хууль зүйн шилжилтийн хөтөлбөрийн захирал Мишел Нуссбаумерыг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр хүлээн авч уулзаж, “Монгол Улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” сэдэвт төслийн асуудлаар;

- Ерөнхий шүүгч Д.Ганзориг Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд Ина Марчюленитег 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцох уулзалт тус тус уулзалт хийсэн байна.

### Шүүхийн даалгаврын хүрээнд

Жилийн эцсийн тайлант хугацаанд шүүхийн даалгавартай холбоотой 105 албан бичгийг холбогдох байгууллагууд руу хугацаа алдалгүй хүргүүлж ажилласан. Үүнд:

Зураг 36



Хилийн чанадаас ирсэн шүүхийн даалгавруудыг харьяалах шүүхэд хүргүүлэн гүйцэтгүүлж нийт 45 даалгаврын хариуг буцаан илгээсэн байна. Хилийн чанадад гүйцэтгүүлэхээр хүргүүлсэн, ажиллагаа нь хийгдэж буй даалгавруудын талаарх нийт 12 лавлагааг илгээсэн ба мөн 3 шүүхийн даалгаврыг шүүхийн бус харьяалах байгууллагад хүргүүлсэн. Мөн хэлбэрийн шаардлага хангаагүй 7 шүүхийн даалгаврыг буцааж хүргүүлсэн байна.

#### 4.4.УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ

Монгол Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Улсын дээд шүүхийн Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, Улс төрийн намын бүртгэлийн алба бий болсон.

Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмыг Улсын дээд шүүхийн нийт хуралдааны 2024



оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулж, хэрэгжүүлж ажиллаж байна.

Зураг 37



Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намуудын цаасан суурьтай хувийн хэргийн цахим мэдээллийн сан үүсгэх, баяжуулах зорилт арга хэмжээний хүрээнд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 намын 116 боть, 26779 хуудас бүхий хувийн хэргийг цахимжуулж сан үүсгэн, баяжилт хийж ажиллаа.

Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улс төрийн намын бүртгэлийг шинэчлэх зорилт арга хэмжээний хүрээнд Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн 2024.07.01-нээс хойш зургаан сарын дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан. Үүний дагуу Монгол Улсын дээд шүүхэд намын дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг бүртгүүлэхээр 8 нам хандаад байна. 8 намын өргөдлийн бүрдлийг шалгаж, хуралдаанд оруулахаар бэлтгэсэн байна.

Улс төрийн намын нэрийн сан хөтлөх, лавлагаа гаргах үйл ажиллагааг зохион байгуулах зорилт арга хэмжээний хүрээнд нам, намын дарга, тамга, тэмдгийн хяналтын дугаар олгосон талаарх лавлагаа -32 намд, намын дүрмийн хуулбар-17 намд, нэрийн баталгаажуулалт-15 иргэн, хуулийн этгээдэд олгосон байна. Өргөдөл, гомдол хүсэлтэд хариу өгөх зорилт арга хэмжээний хүрээнд Улс төрийн намын бүртгэлийн алба 2024 онд 122 албан бичиг, 20 өргөдөл гомдол хүлээн авсан. Уг өргөдөл, гомдлын талаар холбогдох ажиллагааг хийж хугацаанд нь шийдвэрлэж ажилласан байна. Нийт явуулсан албан бичиг 176 байна. Намын бүртгэлтэй холбогдуулан гаргасан шийдвэрийг цахим хуудаст байршуулах, намын хувийн хэрэгт бүртгэх, мэдээлэх ажлыг зохион байгуулах зорилт арга хэмжээний хүрээнд Монгол Улсын дээд шүүхийн цахим хуудаст намын бүртгэлтэй холбоотой 42 мэдээ,

мэдээллийг байршуулсан, Мөн Нийт шүүгчийн хуралдааны тогтоолыг үндэслэн цахим хуудаст 8 намын тогтоолыг байршуулжээ.


Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын хуулиар улс төрийн нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэн бүртгүүлэхтэй холбогдуулан Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас санаачлан “Улс төрийн намын бүртгэл” уулзалт хэлэлцүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хамтран зохион байгуулсан.

Улс төрийн намд тамга, тэмдгийн хяналтын дугаар шинээр олгохтой холбогдуулан тамга, тэмдгийн хяналтын дугаарын сүүлийн 4 оронтой тоог санамсаргүй байдлаар унах систем хийлгэсэн, мөн Сонгуулийн ерөнхий хороонд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намуудын мэдээллийг хүргүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газартай мэдээлэл солилцож ажиллаж байна.

#### 4.5.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 4 удирдамжийг баталж, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж илтгэх хуудсаар Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын бүтцийн нэгжийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дүгнэлт-10, санал, зөвлөмж-39 боловсруулж, гаргасан байна.

Зураг 38



-----oOo-----